



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/35

Өвт

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Насанд хүрэгчдийн гүйлтийн цанын улсын аварга шалгаруулах тэмцээний үеэр “Бээжин-2022” өвлийн олимпид гүйлтийн цанын төрлөөр Монгол Улсаа төлөөлөн оролцсон Бат-Өлзий сумын уугуул, Олон улсын хэмжээний мастер Б.Ачбадрахад хүндэтгэл үзүүлэхэд 2,500,000 (хоёр сая таван зуун мянган) төгрөг, Олон улсын хэмжээний мастер А.Энхтуулд 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөг, дасгалжуулагч багш Г.Баярдэлгэр, Б.Батдорж нарт тус бүр 500,000 (таван зуун мянган) төгрөг, “Бээжин-2022” паралимпийн наадамд оролцсон Ц.Дашдоржид хүндэтгэл үзүүлэхэд 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөг, цанын тэмцээн, цасны баярын тэмцээн уралдааны шагналын зардалд 602,000 (зургаан зуун хоёр мянган) төгрөг, нийт 6,002,000 (зургаан сая хоёр мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 6,002,000 (зургаан сая хоёр мянган) төгрөгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (С.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

622102071

D:My Doc A-4 zahiramj /Zasag Darga/